



“СУРГУУЛИЙН ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН НЭГТГЭЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 24

НЭГ. ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНД ӨГСӨН САНАЛ:

УИХ-ын цахим сүлжээ **D.PARLIAMENT.MN**-ээр дамжуулан хүлээн авсан.



Чиглэл	Үзүүлэлт	Тоо хэмжээ, үзүүлэлт
Цахим сүлжээнд байршсан огноо	Хуулийн төсөл байршсан огноо	2024 оны 11 дүгээр сарын 10
Санал нэгтгэсэн огноо	Санал нэгтгэсэн хугацаа	2025 оны 11 дүгээр сарын 24-ний байдлаар
Нийт төсөлтэй танилцсан иргэдийн тоо	Үзэлтээр	1662 үзэлт
Нийт ирүүлсэн санал	D.PARLIAMENT.MN-ээр иргэдээс ирүүлсэн нийт санал	22 санал
1 дүгээр бүлэг	Саналын задаргаа	1 санал
2 дугаар бүлэг	Саналын задаргаа	14 санал
3 дугаар бүлэг	Саналын задаргаа	7 санал
4 дүгээр бүлэг	Саналын задаргаа	0 санал
Хуулийн төсөлд тусгагдсан байдал	Ирүүлсэн саналуудыг агуулгаар нь нэгтгэж, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх мэдээллийг Нэгдүгээр хавсралт-д бэлтгэж хавсаргасан.	

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДРИЙН 16 ДУГААР ХУРАЛДААНААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Т.МӨНХСАЙХАНЫ САНААЧЛАН БОЛОВСРУУЛСАН СУРГУУЛИЙН ОРЧИНД СУРАЛЦАГЧИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ¹ ХЭЛЭЛЦСЭН ТЭМДЭГЛЭЛД ТУССАН САНАЛЫГ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН ЭСЭХ ТУХАЙ ТАЙЛБАР:

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлд: *19.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төсөл	
ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:	Тайлбар болон санал тусгасан байдал

¹ Хуулийн төслийг 2025.09.10-2025.09.20-ны хооронд эрүүл мэнд, боловсролын салбарын мэргэжилтнүүдийн дунд 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсны үндсэн дээр сургуулийн орчинд зөвхөн суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах нь явцуу тул суралцагчаас гадна багш, ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалсан “Эрүүл мэндийг дэмжигч сургууль”-ийн орчныг төлөвшүүлэх зорилгоор хуулийн төслийн нэрийг **“Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль” болгож өөрчилсөн.** Монгол Улсын Засгийн газар болон холбогдох Яамдаас ирсэн санал нь “Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль”-ийн төсөл гэсэн нэр бүхий төслийн хүрээнд байсан тул тусгасан байдал болон тайлбар нь мөн ижил нэршил ашигласан.

1. Улсын Их Хурлаас 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах буюу хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, үйлчилгээ, нэгдсэн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү зэрэг олон талт, цогц хамтын ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг. Тухайлбал, гэр бүл, нийгмийн болон цахим орчинд эрүүл мэнд, боловсролын салбар, хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгааллыг хэрхэн хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх. урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнг хянах, үнэлэх үйл ажиллагааг уг хуульд нарийвчлан зааж хуульчилсан. Гэтэл сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төслийн зорилго, зохицуулах харилцаа нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа дээрх хуулийн зохицуулалттай давхардаж байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д "хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна" гэж заасны дагуу тусгайлан анхдагч хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэхийг сайтар нягтлах;	1. Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төслийн зохицуулалт нь Хүүхэд хамгааллын тухай хуультай давхцаагүй талаар: Хүүхэд хамгааллын тухай хуулийн зорилго нь “Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад оршино” гэж заасны дагуу ерөнхий хууль бөгөөд тус хуулийн 23 болон 24 дүгээр зүйлд заасан нь дараах агуулгатай байна. 1.1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйл. “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал” “Боловсролын сургалтын байгууллагын орчин, дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэсний дагуу тус зүйл нь хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, дээрэлхэтээс урьдчилан сэргийлэх талаар зохицуулжээ. Харин Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төсөлд дээр дурдсан харилцааг давхардуулан зохицуулаагүй байна. Тус хуулийн төслийн зохицуулах харилцаа нь сургуулийн орчинд суралцагч эрүүл, аюулгүй орчинд суралцах, сургуулиар дамжуулан эрүүл мэндийг дэмжих, хамгаалах буюу <u>эрүүл мэндийг дэмжигч сургуулийн тогтолцоог бий болгох</u>, сургалтын байгууллага дээрх <u>осол гэмтлээс</u> урьдчилан сэргийлэх, түүний улмаас бий болсон хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлагын механизмыг зохицуулна. Түүнчлэн, хуулийн төслийн зохицуулах харилцааг тухайлан авч үзвэл, сургуулийн гадаад болон дотоод орчны агаарын бохирдол, сургуулийн барилгын материалын чанар, элэгдэл, хорогдол, сургалтын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал гэх мэт асуудлаас үүдэлтэй сургуулийн гадаад болон дотоод орчинд осол, гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан осол гэмтэлтэй холбоотой хохирол барагдуулах болон хариуцлага хүлээлгэх тогтолцоог зохицуулах зорилготой.
---	--

	Дээрх агуулга нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан “гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ”-нд хамаарахгүй, зорилгын хувьд давцахгүй ойлголт юм. 1.2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 24 дүгээр зүйл. “Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал” Хүүхэд хамгааллын тухай хуулиар эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар зохицуулдаг. Харин Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төслийн хувьд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдээр хязгаарлаагүй бөгөөд ерөнхий боловсролын сургуулиар дамжуулан 6-17 насны хүүхдийг “эрт илрүүлэг”-т жил бүр хамруулах, тодорхой мөчлөгтэйгөөр өргөтгөсөн /зүрх судасны эрүүл мэнд, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эрүүл мэнд, шээс бэлгийн эрүүл мэнд, амьсгалын тогтолцооны эрүүл мэнд гэх мэтчилэн/ үзлэгт хамруулах тогтолцоог бүрдүүлэх, түүнд үндэслэн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг бий болгох үндсэн зорилготой. Энэ нь Монголын Улсын Алсын Хараа 2050 урт хугацааны бодлого болон түүнд нийцүүлэн гаргасан дунд хугацааны бодлогыг бодитоор хэрэгжүүлэх үндэс болохын зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” хөдөлгөөнд бүрэн нийцнэ. Тиймээс Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төсөл нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23, 24 дүгээр зүйл болон бусад зохицуулалттай давхцал байхгүй. Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулиар “эрүүл мэндийг дэмжигч сургууль”-ийн тогтолцоог бий болгох эрх зүйн үндсийг тодорхойлж, сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлыг бүрдүүлэхтэй холбоотой нэгдмэл харилцааг зохицуулж байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23
--	---

	дугаар зүйлийн 23.1-т заасан "хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай , эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна" гэж заасан нийцэж байна.
2.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.15 дахь хэсэгт суралцагчдад хийх тусгай үзлэг, шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, бусад үзлэг, шинжилгээний зардлыг суралцагчид ногдох хувьсах зардал болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагад олгож байгаа иргэнээр тооцон төсвөөс санхүүжүүлэхээр заажээ. Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг Засгийн газраас тогтоохоор хуульчилсан бөгөөд Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүн"-д хуулийн төсөлд заасан дээрх зардлууд тусгагдаагүй байгааг анхаарах нь зүйтэй.	Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.15-д “Энэ хуулийн 8.5-т заасан тусгай үзлэг, шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх бөгөөд тэдгээрээс бусад энэ хуулийн 8.1-т заасан үзлэг, шинжилгээний зардлыг суралцагчид ногдох хувьсах зардал болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагад олгож буй нэг иргэнээр тооцсон төсвөөс санхүүжүүлнэ” гэж тусгасан бөгөөд үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 53 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын² “Б.Бусад хувьсах зардал”-д хамаарах сургуулийн үйл ажиллагааны урсгал зардал, эрүүл мэндийн үйлчилгээний зардал, хүүхэд хамгааллын зардал болон “В.Нөхөн хангалтын хувьсах зардал”-д хамаарах тоног, төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлуудаар санхүүжүүлэх боломжтой. Өөрөөр хэлбэл, сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой зардлууд дээрх 53 дугаар тогтоолын бүрэлдэхүүнд багтаж байна.
Түүнчлэн, хуулийн төслийн 19 дүгээр зүйлд заасан сургуулийн орчинд тавигдах шаардлагыг Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д "боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна" гэж, мөн хуулийн 39.2-т "энэ хуулийн 39.1-д заасан орчны норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсролын, эрүүл мэндийн болон санхүү,	Хуулийн төслийн 19 дүгээр зүйлд заасан сургуулийн орчны шаардлага нь Боловсролын тухай хуулийн 39.1, 39.2-т заасантай дараах байдлаар уялдана. Боловсролын тухай хуулийн 39.1-т сургалтын орчин нь норм стандартыг хангасан байх талаар заасан бөгөөд тухайн норм стандартыг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн боловсрол, эрүүл мэнд, санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар тусгажээ. Хуулийн төслийн 19 дүгээр зүйлд суралцагчийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах үүднээс сургуулийн орчинд тавигдах нийтлэг шаардлагыг тусгажээ. Энэ нь хуулийн зохицуулалт тул, норм стандартаас давуу

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141293202211&showType=1>

төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэж хуульчилсны дагуу стандарт, норм, нормативаар тогтоон хэрэгжүүлж байна;	хүчинтэй байх бөгөөд норм, стандарт нь хууль тогтоомжид үндэслэн, түүнд нийцүүлэн батлагдана. Өөрөөр хэлбэл хууль нь норм, стандартаас үйлчлэлийн хувьд давуу байна. Тус хуулийн зохицуулалт нь Боловсролын тухай хуулийн 39.1, 39.2-т заасныг үгүйсгээгүй бөгөөд харилцан уялдаатай байна.
3. Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-д нийцүүлэн боловсруулах шаардлагатай." гэжээ. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР	Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-д нийцүүлэн, засварлав.

ГУРАВ. ЯАМНУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛУУДЫГ ТУСГАСАН ЭСЭХ ТУХАЙ ТАЙЛБАРУУДЫН ТЭМДЭГЛЭЛ:

№	Хаанаас	Саналын утга	Судалгааны багийн тэмдэглэл
1	Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан 2024.12.27 ЗГ-2/1010	Танаас 2024 оны 1/2218 дугаартай албан бичгээр ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханаас санаачлан боловсруулсан “Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай” хуулийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. 1.Тус хуулийн төсөл нь Гэмт хэрэг, зерчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7-д "Хүүхдэд хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль дээдлэх ёс, эрх зүйн боловсрол, соёлыг төлөвшүүлэх талаар гэр бүл, нийгэм, сургуулийн орчныг хамарсан цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;" гэсэнтэй хэм хэмжээний давхардал үүсгэхээр; 2.Хуулийн төсөл нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 14 дүгээр зүйл. Урьдчилан сэргийлэх үйлчилгээ, 23 дугаар зүйл. Боловсролын салбар дахь Хүүхэд хамгаалал гэсэн бүлэгтэй ижил харилцааг зохицуулахаар боловсруулсан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д "Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэланхдагч хуулийн төсөл боловсруулна." гэснийг	Ерөнхий байдлаар тусгагдсан ГХЗУСтХ-ийн 7 дугаар зүйлийг хүрээнд сургуулийн орчинд хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой хууль юм. Хуулийн төслийн гол зорилго нь улс даяар “<i>Эрүүл мэндийг дэмжигч сургууль</i>”-ийн тогтолцоог бий болгох эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнд үндэслэн сургуулиар дамжуулан эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, үйлчилгээг тогтмол зохион байгуулж, сургуулийн орчны аливаа аюул ослоос урьдчилан сэргийлэх замаар сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулах зорилготой. Хүүхэд хамгааллын тухай хууль нь гэмт хэрэг, зерчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхийлэлтээс урьдчилан сэргийлэх зорилготой. Дээрхээс ялгаатай нь тус хуулийн төсөл нь сургуулийн орчин дах осол гэмтлээс урьдчилан сэргийлэх механизмийг бүрдүүлсэн. Тус хуулийн төсөл нь норм, стандартыг бодитоор, албадлагагүйгээр хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийг бий болгосон. Түүнчлэн стандарт хангагдаагүйгээс үүсэх хохирлын асуудлыг шийдвэрлэнэ.

		хангаагүй; 3.Сургуулийн орчин, түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т "Үндэсний стандартын төслийг сонирхогч талууд зөвшилцлийн үндсэн дээр санаачлан боловсруулна." гэсний дагуу тус тус шийдвэрлэх боломжтой; 4.Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 29 дүгээр зүйлийн 2-т "... төрөөс тогтоосон боловсролын наад захын жишигт нийцүүлэн сургууль, боловсролын байгууллага байгуулахад чиглэсэн хувь хүн, байгууллагын эрх чөлөөг хязгаарласан байдлаар тайлбарлаж болохгүй." гэж заасныг анхааран үзнэ үү.	
2	Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд 2024.12.30 ЗГ-3/482	Танаас 2024 оны 12 дугаар сарын 09-ний едрийн 1/2218 дугаартай албан бичигтэй танилцлаа. Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна.	Хуулийн төслийг дэмжсэн
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд 2024.12.24 01/6166	Танаас ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханаас санаачлан боловсруулсан "Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах" хуулийн төсөлтэй танилцлаа. Тус хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Хуулийн төслийг дэмжсэн.

4.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд 2024.12.24 01/1990	Танаас 2024 оны 1/2218 тоот албан бичгээр Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төсөлд Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэнтэй танилцаад, дараах саналыг хүргүүлж байна: 1. Хуулийн төслийн 7 дугаар зүйлд суралцагчдад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх чадвар олгох сургалтыг төрийн болон хувийн хэвшлийн аль нэг байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулж байх талаарх зохицуулалтыг нэмэлтээр оруулах талаар судлах; 2. Хуулийн төслийн 7.1-д “Сургууль нь эрүүл мэндийн байгууллагатай хамтран суралцагчийн эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурлан анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.” гэж тусгасан байх бөгөөд сургууль эрүүл мэндийн ямар байгууллагатай хамтран ажиллах, тухайлбал энэ нь аль шатлалын эрүүл мэндийн байгууллага байх, эсхүл хувийн хэвшлийн байгууллага байж болох эсэх талаарх зохицуулалтыг тодорхой болгоход анхаарах; 3. Мөн хуулийн төслийн 7.3-т “Сургуулийн захирал нь эрүүл мэндийн өрөөний стандарт шаардлагыг хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног,	1. МУ-ын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь зөвхөн төрийн өмчийн хэлбэртэй биш тул төрийн болон хувийнхаар ялгах нь төрийн үйл ажиллагаа тэгш эрхийн зарчимд үндэслэгдэх Үндсэн хуулиар тогтоосон зарчмыг зөрчиж болзошгүй юм. 2. Иймд ЭМтХ-д заасан эрүүл мэндийн байгууллага болохын хувьд зохицуулах нь ач холбогдолтой. 3. Энэ Хуулийн заалт нь эцсийн хариуцлагыг хүний нөөц, санхүүгийн эрх бүхий захиралд хүлээлгэх зорилготой бөгөөд сургуулийн дотоод зохион байгуулалтын үйл ажиллагааг зохицуулахгүй тул комисс байгуулахыг хуулиар шаардах шаардлагагүй. 4. Хуулийн төсөлд тусгагдсан. 5. Тус хуулийн төслийн 25.1-д заасны дагуу тус хуулийг зөрчсөн этгээд нь хариуцлага хүлээх тогтолцоо тусгагдсан. 6. Хуулийн төсөлд агуулгын хувьд тусгагдсан. 7. Энэ хуулиар зохицуулах харилцаанд хамаарахгүй бөгөөд Хүүхэд хамгааллын хуулиар зохицуулагдах боломжтой. 8. Хуулийн төсөлд тусгаагүй.
----	--	--	--

		төхөөрөмжийн ашиглалтад тогтмол хяналт тавьж, хэвийн ажиллагааг хангах үүрэгтэй.” гэж тусгасан байх бөгөөд энэ хэсгийг “сургуулийн захирал эрүүл мэндийн өрөөний стандарт шаардлагыг хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмжийн ашиглалтад тогтмол хяналт тавьж, хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий байнгын ажиллагаатай комисс байгуулж, уг комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана” гэж өөрчлөн найруулж болох талаар нягтлах; 4. Хуулийн төсөлд “түүний эцэг, эх, асран хамгаалагч” гэсэн нэр томъёоллыг тусгасан байх бөгөөд уг нэр томъёоллын салшгүй нэг хэсэг болох “харгалзан дэмжигч” гэсэн нэр томъёоллыг нэмж тусгахад анхаарах; 5. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд “Суралцагчийн хувийн халдашгүй байдлыг хангах” зохицуулалтыг тусгасан байх бөгөөд уг зүйлд суралцагчийн хувийн мэдээллийг задруулсан тохиолдолд тооцох хариуцлагын тогтолцоог холбогдох хуультай уяж, нэг мөр зохицуулах; 6. Мөн хуулийн төслийн 22 дугаар зүйлд сургууль, сургуулийн орчинд засвар, үйлчилгээ хийхдээ олон улсын стандартын шаардлага хангасан	
--	--	--	--

		хуухдийн Хүүхдийн эрүүл мэндэд хоргуй барилгын материалыг ашиглах, Үүнд хяналт тавих талаарх зохицуулалтыг илүү нарийвчлан тусгахад анхаарах; 7. Хуулийн төсөл нь хэт ерөнхий байгаагаас гадна суралцагчид бие биенээ ялгаварлан гадуурхах, цахим орчимд булли хийх, бичлэг хийж цацах зэрэг онц ноцтой асуудлуудыг хүлээн авах тусгай утсыг сургуульд ажиллуулах, Мөн сургуулийн нийгмийн ажилтны үүрэг, хариуцлагыг илүү тодорхой болгох зэрэг олон чухал зохицуулалтыг тусгаагүй байх тул эдгээр асуудлуудыг нэмж тусгах талаар сайтар судалж, бусад орны сайн туршлагад тушиглэх, түүнчлэн холбогдох зарим зохицуулалтыг Засгийн газар, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон холбогдох бусад сайд нартай хамтран батлахаар тусгах асуудлыг дахин сайтар нягтлах 8. Мөн түүнчлэн хуулийн төслийн бичвэрийг Хууль тогтоомжийн тухай хууль болон “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д нийцүүлэн боловсруулахад анхаарах.	
--	--	---	--

5.	Батлан хамгаалахын сайд 2024.12.23 1а/4500	Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төсөл болон холбогдох материалтай танилцаад дараах саналтай байна. Үүнд: 1. Хууль санаачлагч нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т «энэ хуулийн 14, 15 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах» гэсэн шаардлагыг хангалгүйгээр хуулийн төслийн үзэл баримтлалыг батлаагүй ирүүлсэн байгааг анхаарах; 2. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсгийн «... мэндийг «... мэндийн .» гэж өөрчлөх зэрэг болно. Гэснийг	Хуулийн төсөлд 1, 2 дах саналыг тус тус тусгасан. Хуулийн төслийн 4.1.3-т хэлбэрийн өөрчлөлт оруулав.
		Таны 2024 оны 1/2218 дугаар албан бичгээр санал авахаар ирүүлсэн "Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай" хуулийн төсөлтэй танилцан дараах саналыг хүргүүлж байна.Үүнд: 1. Төслийн 1.1-д "...сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах..." нь Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 39.1 болон 39.2 дахь хэсэгт зааснаар зохицуулагдах тул төслийн 1.1-д давхцуулахгүй байх.	1. Энэ хуулийн төсөл нь Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 39.1 болон 39.2 дахь хэсэгт заасан зохицуулалтүүдыг сургуулийн орчинд хэрхэн хэрэгжүүлэх процессийг агуулсан зохицуулалт хийх зорилготой тул үндсэн суурь хуулийн заалтүүд болон стандарттай давхцахгүй, зөрчилдөхгүй байна. 2. Яамнууд хариуцсан чиг үүргийн хүрээнд төсвийн хуваарилалтыг хэлэлцэн тогтоох нь зохистой. 3. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн тухай хуулийн 14.3-т зааснаар сургуульд эмч ажиллана. Тус хуулийн төслийн заалт нь тухайн эмч анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл гэх мэт нөөцийг

6.	Боловсролын сайд 2024.12.25 1/2937	2. Төслийн 6 дугаар зүйлд заасан "... үйл ажиллагааны 4 жилийн төлөвлөгөө" -г хэрэгжүүлэх санхүүжилт, хүний нөөцийн зохицуулалтыг маш тодорхой заах. Тухайлбал төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахтай холбоотой санхүүгийн эх үүсвэрийг одоо байгаа боловсролын санхүүжилтийн хөтөлбөрүүдэд тусгах орон зай байхгүй тул боломжтой бол санхүүгийн тусгай хөтөлбөрийг бий болгох зохицуулалтыг Сангийн яамд үүрэгжүүлэх заалт оруулах. Мөн энэ төлөвлөгөөг сургуулийн түвшинд хэн хэрэгжүүлэх, ямар чиг үүрэгтэй байх, эрүүл мэндийн байгууллага ямар үүрэг, оролцоотой байх, холбогдох санхүүжилтийг сургуулийн ямар эх үүсвэрээс гаргах зэрэг асуудлуудыг тодорхойгүй орхисон нь төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болгож байна. 3. Төслийн 7.1-д сургуулийг "эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурласан анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн" байхаар заасан нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.4-д заасантай зөрчилдөж байна. Мөн энэ заалт нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.1-д заасан үндсэн чиг үүрэгтэй зөрчилдөж байна. 4. Төслийн 8.1-д заасан суралцагчийн ээлжит үзлэг шинжилгээг хичээлийн жил эхэлснээс 3 сарын дотор зохион байгуулах тухай заасан нь (1) хичээлийн жилийн	бүрдүүлсэн байх зорилготой бөгөөд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг зорицуулаагүй тул ЭМтХ-ийн зохицуулалт болон СӨБЕБтХ-ийн зохицуулалттай зөрчилдөхгүй юм. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын үндсэн чиг үүргийг хөндөөгүй. 4. Яамны саналыг тодорхой болгоно уу. Үзлэг шинжилгээ хийх нь яагаад “сургалтын үйл ажиллагаа”-ны хугацаад явагдах боломжгүй гээд байгаа нь ойлгомжгүй байна. 5. Тус хуулийн төслийн 8.1-д эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг зохион байгуулах этгээдийг тодорхой тусгасан тул “үзлэг, шинжилгээ зохион байгуулагч” гэдэгт мөн адил ойлгоно. 6. Яамнууд хариуцсан чиг үүргийн хүрээнд төсвийн хуваарилалтыг хэлэлцэн тогтоох нь зохистой. 7. Тус хуулийн төсөлд Сургуулийн захирал нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагуудтай хамтран ажиллах бүрэн эрхийг тусгасан тул мэргэжлийн байгууллагыг туслалцаатайгаар арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжтой байдлаар туссан. 8. Яамнууд хариуцсан чиг үүргийн хүрээнд төсвийн хуваарилалтыг хэлэлцэн тогтоох нь зохистой. 9. Саналыг Хуулийн төсөлд тусгасан. 10. Дархлаажуулалтын тухай хуулийн 8.1-д заасан байгууллагууд дархлаажуулалтыг зохион байгуулах үүрэгтэй бөгөөд үүнд нутгийн захиргааны байгууллага багтсан байх бөгөөд сургуулийн захиралтай хамтран ажиллахгүйгээр сургууль дээр дархлаажуулалтыг зохион байгуулах боломжгүй юм. Иймд сургуулийн захирал дархлаажуулалтын зохион байгуулалтад ямар чиг үүрэгтэйгээр оролцохыг тус хуулийн төслөөр
----	---------------------------------------	--	---

		бутэц, сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалттай нийцэхгүй (2) зохион байгуулалтад оролцох этгээдүүдээс хэн нь юу хийх талаар тусгаагүй байгаа нь хууль батлагдсан тохиолдолд энэ заалтыг хэрэгжүүлэх ямар ч боломжгүй болгож байна. Нөгөө талаас энэ нь Сургуулийн өмнөх болон ерөнхий Боловсролын тухай хуулийн 5.2 болон 5.3-д заасан хугацааг мөрдөх боломжгүй болгож байна. 5. Энэ заалтад үндэслэсэн 8.9 дэх хэсэг "үзлэг шинжилгээг зохион байгуулагч нь..." гэж заасан нь тодорхойгүй зохицуулалт байна. 6. Төслийн 8.15-д заасан тусгай үзлэг шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр заасан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан зохицуулалттай зөрчилдөхөөр байна. Өөрөөр хэлбэл төслийн 8.1-д эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэн зохион байгуулагч байхыг тодорхой заагаагүйгээс сургууль өөрөө энэ тусламж, үйлчилгээг зохион байгуулагч байж болох нөхцөлийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хуулийн 10.1 заалттай зөрчилдөхөөр байна. Түүнчлэн 8.15-д "хуулийн 8.1-д заасан үзлэг шинжилгээний зардлыг суралцагчид ногдох хувьсах зардал..."-аас санхүүжүүлэх тухай заасан нь Боловсролын ерөнхий хуулийн 38.1.2 дахь заалттай нийцэхгүй байна.	тусгасан тул дээрх хуулийн заалттай зөрчилдөхгүй юм. 11. Яамнууд хариуцсан чиг үүргийн хүрээнд төсвийн хуваарилалтыг хэлэлцэн тогтоох нь зохистой. 12. Хуулийн төслийн 19 дүгээр зүйлд заасан зохицуулалт нь сургуулийн орчноос шалтгаалсан осол болон өвчнийг анхнаас нь үүсгэхээс сэргийлэх зорилготой бөгөөд тогтвортой хэрэгжих ёстой зохицуулалт тул стандарт бус хуулиар зохицуулах нь ач холбогдолтой. Практикт стандарт болон хуулийн зохицуулалтын үр дагавар харилцан адилгүй байгаа. Хэрэв стандарт болон хуулийн хэм хэмжээ давхардсан эсхүл, зөрчилдсөн тохиолдолд хуулийн хэм хэмжээ нь үйлчлэлийн хувьд давуу байна. Тус хуулийн зохицуулах харилцааг стандартад найдан орхигдуулсан тохиолдолд, тус харилцаа зохицуулалтгүй үлдэх, эсхүл одоо байгаа зохицуулалтаас дордуулах эрсдэлтэй. 13. Хуулийн 21.1 дэх заалт байснаар сургуулийн орчны эрүүл ахуйн стандарт хангагдахад бодит түлхэц үзүүлнэ. 14. Хяналтыг хэрэгжүүлэх, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс тогтмол шалгалт хийх шаардлагатай. 15. Иргэний хуулийн 498 дугаар зүйлд заасны дагуу хохирлыг ажил олгогч тэргүүнд ээлжинд хариуцан арилгана. Түүний дараа хэрэв ажилтан нь тухайн хохирлыг үүсгэхэд санаатай эсхүл илтэд болгоомжгүй байсан тохиолдолд ажил олгогч буюу байгууллага ажилтнаас хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Хэрэв энэ журмыг дурдаагүй тохиолдолд ажилтны гэм буруугийн хэмжээг харгалзахгүйгээр ажилтнаас нөхөн төлбөрийг шаардах эрх зүйн үр дагавартай. Энэ тохиолдолд ажилтны эрх ашиг дордоно.
--	--	---	--

		7. Төслийн 10.2-д заасан суралцагчийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахтай холбогдох арга хэмжээг мэргэжлийн байгууллага сургуулиас зохион байгуулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. 8. Төслийн 10.3-д заасан зардлыг сургууль хариуцах боломжгүй болно. Боловсролын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлээр сургуулийн санхүүжилт зохицуулагдана. 9. Төслийн 12 дугаар зүйлд заасан суралцагчийн сэтгэцийн эрүүл мэнд гэснийг суралцагчдад үзүүлэх сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ гэж солих саналтай байна. 10. Төслийн 14.1 дэх хэсэг нь Дархлаажуулалтын тухай хуулийн 8.1 дэх заалттай нийцэхгүй гэж үзэж байна. 11. Төслийн 15.4 дэх хэсэгт тусгасан санхүүжилтийг Төсвийн ямар эх үүсвэрээс санхүүжүүлэхийг тодорхой болгох. 12. Төслийн 19 дүгээр зүйл нь бүхэлдээ Боловсролын ерөнхий хуульд заасан орчны стандарт, техникийн зохицуулалтад тусгах боломжтой тул хуулийн төсөлд тусгах шаардлагагүй гэж үзэж байна. 13. Төслийн 21.1 дэх хэсгийг хуулийн төсөлд тусгах шаардлагагүй гэж үзэж байна. 14. Төслийн 23.1-д заасан "хяналт, шалгалт" гэдгийг "хяналт" болгох 15. Төслийн 21.2 дахь хэсэгт дурдсан Иргэний хуулийн 498 дугаар зүйл нь сургуулийн ажиппагсдад хамаарахыг анхаарах нь зүйтэй.	
--	--	---	--

7.	Гадаад харилцааны сайд 2024.12.19 09/5972	Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төслийг дэмжиж байна.	Хуулийн төслийг дэмжсэн.
8.	Зам, тээврийн сайд 2024.12.25 01/2469	Таны 2024 оны 12 дугаар сарын 09-ний едрийн 1/2218 дугаар албан бичгээр ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан "Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай" хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т "энэ хуулийн 14, 15 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах" гэж заасны дагуу үзэл баримтлалыг батлаагүй байгааг анхаарахыг хүсье.	Хэлбэрийн шаардлага хангана.
9	Сангийн сайд 2024.12.30. 01/2695	Таны 2024 оны 12 дугаар сарын 09-ний едрийн 1/2218 тоот албан бичгээр санал авахаар ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах хуулийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.Үүнд: 1. Хуулийн төслийн 6.5, 15.4, 15.10-т улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйл ажиллагааны талаар тусгасан боловч Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх	1. Яамдууд хариуцсан чиг үүргийн хүрээнд төсвийн хуваарилалтыг ярилцаж тохирох, зохицуулалтын төсөл эцэслэгдсэний дараа зардлын тооцоог эцэслэж засна. 2. Хуулийн төслийн 8.1-д "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллага" тусгах шаардлагагүй. Учир нь тус хуулийн төслийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах бүрэн эрхийг сургуулийн захиралд олгосон бөгөөд 3. Нөгөө талаараа эрүүл мэнд байгууллага /өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллага/ хамтран ажиллах хүсэлтээс үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй. 4. "Доошгүй" гэж ойлгоно.

	хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно" гэж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалтад "Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь Төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх;" гэж тус тус заасны дагуу хуулийн төсөлтэй хамт ирүүлсэн зардлын тооцоонд хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоо болон төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтийг ирүүлээгүй байгааг анхаарах; 2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн эрүүлсэн мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн чиг үүрэг, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, санхүүжүүлэх төлбөрийн арга, журмыг тусгайлан зохицуулсан. Тухайлбал, өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын санхүүжилтийг өрхийн эмчид бургтүүлсэн иргэнээр тооцож, "нэг иргэнээр тооцсон төлбөрийн арга"-аар санхүүжүүлж байна. Харин хуулийн төслийн 8.15-д "...8.1-т заасан үзлэг, шинжилгээний зардлыг суралцагчид ногдох хувьсах зардлыг суралцагчид ногдох	5. Хариуцах этгээдийг тодорхой болгож өгснөөр хууль зүйн мэргэжлийн мэдлэггүй этгээд ч ойлгоход хялбар болно. Ингэснээр тус хариуцлага хүлээх этгээд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой болно.
--	--	---

		хувьсах зардал болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагад олгож буй нэг иргэнээр тооцсон төсвөөс санхүүжүүлнэ" гэж заасан нь дээрх хуульд зохицуулсан нэг иргэнээр тооцсон төлбөрийн болон санхүүжилтийн аргатай зөрчилдөхөөр байгааг анхаарах. 3. Мөн хуулийн төслийн 8.1- д "өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллага" гэж нэмэх; 4. Хуулийн төслийн 19.1.2, 19.1.3-т тусгагдсан "багагүй хэмжээнд" гэснийг хэрхэн ойлгох нь тодорхой бус байгааг анхаарах; 5.Хуулийн төслийн 20.2-т "сургуулийн барилга, байгууламж норм, стандарт хангаагүйн улмаас бусдад хохирол учруулбал Иргэний хуулийн 498 дугаар зүйлд заасан журмыг баримталж, хохирлыг барагдуулна" гэх агуулгаар өөрчлөх зэрэг болно.	
10.	Гэр бүл, хөдөлмөр, хамгааллын сайд 2024.12.23 01/1729	Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах хуулийн төсөлд өгөх санал: 1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйл, 24 дүгээр зүйл, 48 дугаар зүйлтэй уялдуулан хуулийн төсөлд тодорхой зохицуулалт тусгах. 2.Мэрээллийн сангийн зохицуулалтыг уялдуулах. 3. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 14 дүгээр зүйл, 23 дугаар зүйлтэй уялдуулсан зохицуулалт нэмэх	1. Ирүүлсэн 1, 2, 3- саналыг тодорхой болгох, уялдаагүй хэсэг юу болохын саналдаа тодорхой ирүүлээгүй. 2. Хуулийн төсөлд Хүүхэд хамгааллын тухай хуулийн зорилготой уялдаатай байдлаар зохицуулалт хийгдсэн бөгөөд тухайлсан харилцааг давхардуулахгүйн үүднээс Хүүхэд хамгааллын тухай хуулийн тухайлсан зохицуулалтыг дахин зохицуулаагүй. 3. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуультай уялдуулан өгөгдөл цуглуулах зохицуулалтыг боловсруулсан.

11.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 2024.12.25-01/4151	Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулж, Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах хуулийн төсөл, холбогдох материалтай танилцаад дараах саналыг хүргүүлж байна.Үүнд: 1. Хуулийн төслийн 8.4 дэх хэсгийг "Эрүүл мэндийн ерөнхий үзлэг, шинжилгээг жил бүр зохион байгуулах бөгөөд Үүнд бие бялдрын үнэлгээ, хараа, сонсгол, шүдний үзлэг, шинжилгээ багтах ба нэгээс арван хоёрдугаар ангийн нийт суралцагчид хамрагдана" гэх агуулгаар найруулан өөрчлөх; 2. Хуулийн төслийн 8.5 дахь хэсэг нь Боловсролын ерөнхий хуулийн 10.1.10 дахь заалттай зөрчилдөж буйг анхаарах; 3. Хуулийн төслийн 9.1. дэх хэсэгт "анги удирдсан багш, сургуулийн нийгмийн ажилтан" нарыг нэмж тусгах саналтай байна.	1. Хуулийн төслийн 8.4, 8.5-д саналын агуулга ижил тул зохицуулалт өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн 2. Тус хуулийн төслийн 8.8-д Боловсролын ерөнхий хуулийн 10.1.10 зааснаар бичгээр татгалзсан тохиолдолд үзлэг, шинжилгээ хийхгүй байхаар зохицуулсан тул энэ хуулийн төслийн 8.5 нь Боловсролын ерөнхий хуулийн 10.1.10-д заасантай зөрчилдөхгүй. 3. Энэ заалт нь үзлэг, шинжилгээ хийсэн этгээд нь дотоод харилцаанд сургуультай зөвхөн сургуулийн захирал, сургуулийн эмчээр дамжуулж мэдээлэл солилцох бөгөөд хэт олон субъектэд мэдээлэл дамжуулахаар зохицуулалт хийх мэдээлэл алдагдах эрсдэлийг нэмэгдүүлнэ.
12.	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд 2024.12.24 01/1524	Монгол Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан "Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль"-ийн төсөл, холбогдох бичиг баримттай танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн "төрийн захиргааны төв байгууллага" гэсний дараа", аймаг, нийслэлийн Засаг дарга" гэж нэмэх, 20.2, 21.2 дахь хэсгийн агуулга давхцаж байх тул нэгтгэж, "учирсан хохирлыг Иргэний хууль болон холбогдох хууль	1. Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн "төрийн захиргааны төв байгууллага" гэсний дараа", аймаг, нийслэлийн Засаг дарга" гэж нэмсэн. 2. Хуулийн төслийн 20.2 болон 21.2 дахь зохицуулалт нь ялгаатай зохицуулалт. 20.2-т "Сургуулийн барилга, байгууламж, биеийн тамирын талбай, сургуулийн эзэмшил газар дээрх аюулгүй байдалд" хамааралтай бол, 21.2-т зөвхөн сургуулийн барилга байгууламжийг хамруулсан байгаа. Өөрөөр хэлбэл, гэм хор, үүргийн хүрээ нь ялгаатай.

		тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ." гэж өөрчлөн найруулах саналтай байна.	
13.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд 2025.01.03. 01/10	Танаас ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах хуулийн төсөлтэй танилцлаа. Хуулийн төсөлд дараах саналтай байна: 1. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн "Сургууль нь" гэсний дараа "энэ хуулийн" гэж нэмэх; 2. Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн "Энэ хуулийн 23.1-д заасан эрүүл ахуйн хяналт, шалгалтыг зохион байгуулахдаа сургуулийн зөвлөлийн эцэг эхийн төлөөллийг оролцуулна" гэснийг, хуулийн төслийн 23.3 дахь хэсгийн "Энэ хуулийн 23.1-т заасан хяналт, шалгалтыг явуулахдаа эрүүл ахуй болон хүнсний эрүүл ахуй хариуцсан эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана" гэсэнтэй нэгтгэн "Энэ хуулийн 23.1-д заасан эрүүл ахуйн хяналт, шалгалтыг зохион байгуулахдаа сургуулийн зөвлөлийн эцэг эхийн төлөөллийг оролцуулж, эрүүл ахуй болон хүнсний эрүүл ахуй хариуцсан эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана" гэж өөрчлөх найруулах.	1. Хуулийн төслийн 8.7-д тусгасан. 2. Хуулийн төсөлд нарийвчлан тусгагдсан тул агуулгын хувьд заалтуудыг ерөнхийлөн өөрчлөх шаардлагагүй гэж үзэв.

14.	Эрчим хүчний сайд 2024.12.31. а/4359	Танаас ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал болон холбогдох материалыг хулээн авч танилцлаа. Хуулийн төсөлд тус хорооны зүгээс тусгайлан өгөх саналгүй байна.	Тусгайлан санал өгөөгүй
-----	---	---	-------------------------

15.	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд 2025.12.31. 01/1473	Танаас ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачлан боловсруулсан Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төсөлтэй танилцаад тусгайлан өгөх саналгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д “энэ хуулийн 14,15 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах” гэж заасны дагуу батлагдсан үзэл баримтлалтай ирүүлж байхыг хүсье.	Үзэл баримтлал хэлбэрийн шаардлага хангасан бөгөөд өөр тусгайлсан саналгүй.
16.	Хяналт, үнэлгээний хороо Үндэсний хороо 2024.12.25 01/484	Танаас 2024 оны 12 дугаар сарын 09-ний едрийн 1/2218 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэн "Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай" хуулийн төсөлтэй танилцлаа. Тус хуулийн төслийг дэмжиж байна.	Тусгайлсан саналгүй. Хуулийн төслийг дэмжсэн
17.	Боомтын сэргэлтийн Үндэсний Хороо 2024.12.13. 01/1325	Танаас ирүүлсэн “Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай” хуулийн төсөл, холбогдох материалтай танилцлаа. Хуулийн төсөлд тус хорооны зүгээс тусгайлан өгөх саналгүй байна.	Тусгайлсан саналгүй.